



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар A/06

Бсонбулаг

[Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн]
стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ш.Эрдэнэбат	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд:	Я.Жаргалцэцэг	(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)
	Ч.Хандмаа	(Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Л.Хаш-Эрдэнэ	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
	Х.Баатарзориг	(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
	С.Мөнхжаргал	(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга:	Э.Пүрэвжав	(Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Д.Төмөрбаатар	(Цэргийн штабын дарга)
	Р.Мягмаржаргал	(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан журам болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу боловсруулж, 2024 оны нэгдүгээр улиралд багтаан батлуулахыг ажлын хэсэг (Ш.Эрдэнэбат)-т даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О АМГАЛАНБААТАР

